



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
БҮСИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2026 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А/27

Арвайхээр сум

**Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн чанарын менежментийн
тогтолцооны хамрах хүрээ, нэгдсэн үйл явцын бүтцийг батлах тухай**

Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн Хөдөлмөрийн дотоод хэм хэмжээний журмын 4.7.3, 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн, байгууллагын үйл ажиллагаанд MNS ISO 9001:2016 “Чанарын менежментийн тогтолцоо – Шаардлага” стандартыг нэвтрүүлэх, хэрэгжүүлэх ажлын хүрээнд ТУШААХ нь:

1.Өвөрхангай аймаг дахь Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн чанарын менежментийн тогтолцооны хамрах хүрээг байгууллага бүхэлд нь байхаар тогтоож, чанарын менежментийн тогтолцооны хамрах хүрээний зураглалыг нэгдүгээр, чанарын менежментийн тогтолцооны нэгдсэн үйл явцын бүтэц, зураглалыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан хамрах хүрээ, үйл явцын бүтэцтэй уялдуулан байгууллагын үйл ажиллагаанд чанарын менежментийн тогтолцооны шаардлагыг хэрэгжүүлэх, үйл явцын гүйцэтгэлийг тогтмол хянах, эрсдэл ба боломжид суурилсан сэтгэлгээг хэвшүүлэх, тасралтгүй сайжруулалтын арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж ажиллахыг Сургалт хөгжил, бодлого төлөвлөлт гүйцэтгэлийн албаны дарга, менежментийн тогтолцооны менежер (Д.Аззаяа), тасаг, нэгжийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Чанарын менежментийн тогтолцооны хамрах хүрээ, үйл явцын бүтэцтэй холбоотой өөрчлөлт, шинэчлэлтийг байгууллагын үйл ажиллагааны онцлог, эрх зүйн орчин, хэрэглэгчийн шаардлагатай уялдуулан тухай бүр хянаж, шинэчлэн боловсруулж байхыг Чанарын менежментийн багт үүрэг болгосугай.


4.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэл зүй эрхэлсэн дэд захирал (Д.Болормаа)-д даалгасугай.

ЗАХИРАЛ



Т.ДАШЖАНЦАН

Өвөрхангай аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн хамрах хүрээний үйл явцын схем



“БОЭТ” ISO9001 ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ҮЙЛ ЯВЦЫН СХЕМ

